



**ХЭНТИЙ АЙМАГ
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/49

Бэрх

**Бэрх олон улсын сургуулийн
хүүхэд хамгааллын багийн бүрэлдэхүүнийг
томилох тухай**

Монгол Улсын Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэрх хотын Бэрх олон улсын сургуулийн “Хүүхэд хамгааллын баг” –ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч:	Л.Оюунгэрэл	Сургуулийн захирал
Нарийн бичгийн дарга:	А.Оюунтуяа	Нийгмийн ажилтан
Гишүүд:	Ц.Байгалмаа	Сургалтын менежер
	Х.Баасанжав	Дотуур байрны багш
	Н.Үүрцайх	Монгол хэл, уран зохиолын багш

2. Тус хотын Бэрх олон улсын сургуулийн хүүхэд бүрийг сургууль болон дотуур байр, гэр бүлийн орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны болон үе тэнгийн дарамт, гэмт хэрэг зөрчилд хохирогч болон холбогдогч болгохоос урьдчилан сэргийлэх, хорт зуршилд өртүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлэн ажиллахыг хүүхэд хамгааллын баг болон анги удирдсан багш нарт даалгасугай.

3. Хүүхэд хамгааллын бодлого боловсруулж, бодлого хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажиллаж ажиллагааны явцыг эцэг эх, асран хамгаалагч, багш ажилчид, сурагчдад тайлагнаж байх, жилийн эцсийн хийсэн ажлын тайланг аймгийн Боловсрол соёл урлагийн газарт хүргүүлж ажиллахыг Бэрх олон улсын сургуулийн Захирал /Л.Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ  Н.ЭНХЖАВХЛАН